



АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Баянгол дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/06/НА-СА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын
хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 11327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ундармаа
Аудитор: Д.Нарантуяа
Л.Энх-Амгалан
Г.Тэмүүжин
Утас: 11325093

Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn
Цахим хаяг: narantuyad@audit.gov.mn
Цахим хаяг: enkhamgalanl@audit.gov.mn
Цахим хаяг: temuujing@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дүүргийн засаг дарга Нийслэлийн Засаг даргатай хийсэн гэрээгээр нийт 3 зорилт 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 99.4 хувиар үнэлүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		9,106,928.90	27,070,853.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	5,033,226.90	20,710,750.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	57,668.50	34,627.00
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	57,407.40	21,651.60
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	3,342,510.70	5,752,300.40
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	34,800.00	19,103.80
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	581,315.40	532,419.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		115,346,977.20	118,298,491.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	115,346,977.20	118,298,491.80
39200	Биет хөрөнгө		107,945,408.60	109,798,456.90
39300	Биет бус хөрөнгө	13	7,401,568.60	8,500,034.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		124,453,906.00	145,369,344.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,987,352.20	3,717,488.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	2,987,352.20	3,717,488.90
41300	Өглөг	17а, 17б	772,120.20	1,125,843.20
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	2,215,232.00	2,591,645.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		121,466,553.80	141,651,856.00
51	Засгийн газрын хувь оролцоо		121,466,553.80	141,651,856.00
51100	Засгийн газрын оруулсан капитал		33,886,253.60	33,886,253.60
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		132,500.00	132,500.00
51200	Хуримтлагдсан үр дүн		49,636,664.10	69,821,966.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		124,453,906.00	145,369,344.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		159,082,155.60	207,346,045.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО		130,210,000.00	187,371,001.70
110	Орлогын албан татвар		111,724,168.50	165,157,816.10
1100	Хувь хүний орлогын албан татвар		111,724,168.50	165,157,816.10
113	Хөрөнгийн албан татвар		8,817,582.30	11,406,129.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж		9,668,249.20	10,807,056.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	27,109,609.20	18,448,379.10
120	Нийтлэг татварын бус орлого		25,844,033.10	16,462,304.10
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		1,265,576.10	1,986,075.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,762,546.40	1,526,665.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	154,266,378.60	187,107,225.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		154,266,378.60	187,107,225.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		56,378,649.40	60,112,162.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,903,774.00	14,636,882.70

Нийслэлийн Баянгол дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,429,863.00	1,932,691.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,392,285.90	5,788,534.40
2104	Хангамж, бараа материалын зардал		621,519.40	2,156,318.70
2105	Нормативт зардал		2,649.40	136,681.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		987,664.90	1,094,020.70
2107	Томилолт, зочны зардал		296,449.60	502,309.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		23,017,276.80	17,234,278.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		14,727,166.40	16,630,445.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		97,887,729.20	126,995,062.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,815,777.00	20,238,820.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		138,052,400.60	53,518.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-133,236,623.70	20,185,302.20

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	78,124,484.71	120,010,178.92	56,568,948.86	254,703,612.48
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(44,105,731.08)	(82,230,162.07)	126,304,338.96	(31,554.20)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,018,753.63	37,780,016.84	182,873,287.82	254,672,058.28
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	31,119.21	-	31,119.21
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(133,236,623.69)	(133,236,623.69)
10	2022 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	34,018,753.63	37,811,136.06	49,636,664.13	121,466,553.81
11	2023 оны 1-р сарын 1-нээх үлдэгдэл	34,018,753.63	37,811,136.06	49,636,664.13	121,466,553.81
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,018,753.63	37,811,136.06	49,636,664.13	121,466,553.81
19	Тайлант үеийн үр дүн	-	-	20,185,302.23	20,185,302.23
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	34,018,753.63	37,811,136.06	69,821,966.35	141,651,856.03

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	136,961,003.90	196,142,684.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	130,210,000.00	187,371,001.70
110	Орлогын албан татвар	111,724,168.50	165,157,816.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	111,724,168.50	165,157,816.10
113	Хөрөнгийн албан татвар	8,817,582.30	11,406,129.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	9,668,249.20	10,807,056.00

Нийслэлийн Баянгол дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,712,972.90	3,709,367.10
1181	Газрын төлбөр	5,948,464.90	7,097,688.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,811.40	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,916,148.20	7,245,018.10
120	Нийтлэг татварын бус орлого	3,650,572.10	5,258,943.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,265,576.10	1,986,075.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,834,855.70	1,526,665.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	133,839,348.00	171,859,927.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	133,839,348.00	171,859,927.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,691,733.90	43,404,539.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,183,985.60	18,035,141.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,449,680.80	2,966,560.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,483,621.00	5,876,124.40
2104	Хангамж, бараа материалын зардал	2,841,600.60	4,999,263.20
2105	Нормативт зардал	15,175.30	119,407.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	996,017.20	1,160,226.70
2107	Томилолт, зочны зардал	328,262.20	469,538.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,769,271.30	5,036,208.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,624,120.00	4,742,068.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,147,614.10	128,455,388.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,121,655.90	24,282,757.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,055,521.80	8,605,233.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,055,521.80	8,605,233.70
2200	Дотоод эх үүсвэрээр	11,055,521.80	8,605,233.70
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-11,055,521.80	-8,605,233.70
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-7,933,865.90	15,677,523.90
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,967,092.80	5,033,226.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,033,226.90	20,710,750.80

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	188,155,625,400.00	178,543,119,595.65	9,612,505,804.35	94.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,973,225,400.00	170,677,342,923.65	2,295,882,476.35	98.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,622,400,900.00	42,242,854,922.95	1,379,545,977.05	96.8%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,852,255,900.00	14,636,882,723.90	215,373,176.10	98.5%
210101	Үндсэн цалин	5,798,890,000.00	5,829,013,401.47	-30,123,401.47	100.5%
210102	Нэмэгдэл	2,449,973,900.00	2,632,696,891.49	-182,722,991.49	107.5%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,506,113,000.00	1,501,774,337.51	4,338,662.49	99.7%
210104	Урамшуулал	1,461,038,300.00	1,142,186,895.43	318,851,404.57	78.2%
210105	Гэрээт ажлын хөлс	3,636,240,700.00	3,531,211,198.00	105,029,502.00	97.1%

Нийслэлийн Баянгол дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,004,555,800.00	1,932,705,098.78	71,850,701.22	96.4%
210201	Тэтгэврийн даатгал	1,396,545,600.00	1,357,334,944.93	39,210,655.07	97.2%
210202	Тэтгэмжийн даатгал	150,293,400.00	148,543,895.03	1,749,504.97	98.8%
210203	ҮОМШӨ-ний даатгал	131,515,400.00	116,569,956.48	14,945,443.52	88.6%
210204	Ажилгүйдлийн даатгал	29,646,800.00	28,159,435.27	1,487,364.73	95.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	296,554,600.00	282,096,867.07	14,457,732.93	95.1%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,329,298,900.00	5,788,054,406.85	541,244,493.15	91.4%
210301	Гэрэл, цахилгаан	1,857,590,400.00	1,487,578,711.50	370,011,688.50	80.1%
210302	Түлш, халаалт	2,204,361,200.00	2,057,813,484.32	146,547,715.68	93.4%
210303	Цэвэр, бохир ус	1,313,322,700.00	1,270,219,177.69	43,103,522.31	96.7%
210304	Байрны түрээс	954,024,600.00	972,443,033.34	-18,418,433.34	101.9%
2104	Хангамж, бараа материалын зардал	6,980,049,300.00	6,950,160,697.98	29,888,602.02	99.6%
210401	Бичиг хэрэг	213,766,600.00	212,304,835.00	1,461,765.00	99.3%
210402	Тээвэр, шатахуун	60,198,200.00	55,825,600.00	4,372,600.00	92.7%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	137,274,400.00	123,068,873.48	14,205,526.52	89.7%
210404	Ном, хэвлэл	19,645,700.00	19,614,650.00	31,050.00	99.8%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,328,575,200.00	6,325,395,000.00	3,180,200.00	99.9%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	220,589,200.00	213,951,739.50	6,637,460.50	97.0%
2105	Нормативт зардал	133,624,900.00	119,407,630.00	14,217,270.00	89.4%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,055,100.00	2,382,130.00	672,970.00	78.0%
210502	Хоол, хүнс	106,530,000.00	106,530,000.00	0.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,039,800.00	10,495,500.00	13,544,300.00	43.7%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,635,755,600.00	1,587,732,241.00	48,023,359.00	97.1%
210601	Багаж, техник, хэрэгсэл	451,904,800.00	414,701,935.00	37,202,865.00	91.8%
210602	Тавилга	20,830,000.00	20,810,000.00	20,000.00	99.9%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	22,150,000.00	18,027,800.00	4,122,200.00	81.4%
210604	Урсгал засвар	1,140,870,800.00	1,134,192,506.00	6,678,294.00	99.4%
2107	Томилолт, зочны зардал	484,663,300.00	469,538,840.70	15,124,459.30	96.9%
210701	Гадаад албан томилолт	471,413,000.00	458,164,540.70	13,248,459.30	97.2%
210702	Дотоод албан томилолт	6,124,000.00	4,248,000.00	1,876,000.00	69.4%
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,126,300.00	7,126,300.00	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,497,955,200.00	4,412,172,186.60	85,783,013.40	98.1%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,311,412,500.00	4,232,674,849.00	78,737,651.00	98.2%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0	500,000.00	0.0%
210803	Даатгалын үйлчилгээ	3,581,000.00	1,239,855.00	2,341,145.00	34.6%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,758,300.00	1,003,788.00	754,512.00	57.1%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	808,000.00	427,000.00	381,000.00	52.8%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,425,000.00	2,522,155.00	2,902,845.00	46.5%

**Нийслэлийн Баянгол дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	25,470,400.00	25,304,539.60	165,860.40	99.3%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	149,000,000.00	149,000,000.00	0.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,704,242,000.00	6,346,201,097.14	358,040,902.86	94.7%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,627,992,000.00	6,273,494,397.14	354,497,602.86	94.7%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,250,000.00	72,706,700.00	3,543,300.00	95.4%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,350,824,500.00	128,434,488,000.70	916,336,499.30	99.3%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	128,399,977,000.00	127,540,168,318.70	859,808,681.30	99.3%
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	128,399,977,000.00	127,540,168,318.70	859,808,681.30	99.3%
2132	Бусад урсгал шилжүүлэг	950,847,500.00	894,319,682.00	56,527,818.00	94.1%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,447,500.00	52,447,500.00	0.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	898,400,000.00	841,872,182.00	56,527,818.00	93.7%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,182,400,000.00	7,865,776,672.00	7,316,623,328.00	51.8%
220001	Барилга байгууламж	1,653,200,000.00	1,125,261,719.00	527,938,281.00	68.1%
221001	Их засвар	9,310,800,000.00	2,917,755,473.00	6,393,044,527.00	31.3%
222001	Тоног төхөөрөмж	4,139,000,000.00	3,743,359,480.00	395,640,520.00	90.4%
223001	Бусад хөрөнгө	79,400,000.00	79,400,000.00	0.00	100.0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	188,155,625,400.00	179,068,869,056.95	9,086,756,343.05	95.2%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,016,653,600.00	1,986,075,080.00	30,578,520.00	98.5%
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	2,016,653,600.00	1,986,075,080.00	30,578,520.00	98.5%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	181,241,839,900.00	176,161,337,236.95	5,080,502,663.05	97.2%
320001	Орон нутгийн төсвөөс	181,241,839,900.00	176,161,337,236.95	5,080,502,663.05	97.2%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,897,131,900.00	921,456,740.00	3,975,675,160.00	18.8%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	886,320,000.00	900,510,780.00	-14,190,780.00	101.6%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,680,000.00	20,945,960.00	1,734,040.00	92.4%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,988,131,900.00	0	3,988,131,900.00	0.0%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,679.00	1,505.00	174.00	89.6%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	11	11	0.00	100.0%
610001	Төсвийн байгууллага	11	11	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	834	747	87.00	89.6%
620001	Удирдах ажилтан	64	61	3.00	95.3%
620002	Гүйцэтгэх ажилтан	359	312	47.00	86.9%
620003	Үйлчлэх ажилтан	105	81	24.00	77.1%
620004	Гэрээт ажилтан	306	293	13.00	95.8%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	834	747	87.00	89.6%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	184	181	3.00	98.4%
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	6	6	0.00	100.0%

Нийслэлийн Баянгол дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	313	239	74.00	76.4%
650010	Гэрээт ажилтан	294	285	9.00	96.9%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	37	36	1.00	97.3%

2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,536,799,991.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,536,799,991.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,515,899,991.57
2104	Хангамж, бараа материалын зардал	2,540,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,700,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,900,000.00
210602	Тавилга	2,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	342,024,991.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	342,024,991.57
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,156,635,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,156,635,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,900,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,536,799,991.57
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,536,799,991.57
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	25,846,981.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,316,670,292.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	194,282,717.86

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсвийн байгууллага (ИТХ, ЗДТГ, ЖДУДТ, ХААА, ГБЕО, ДАА, УССТ, Гэрэлт.Тох.үйлчилгээний алба) 2 зардал, (ОНХС, Хөрөнгө оруулалт-барьцаа), аж ахуйн тооцоотой 5 байгууллага (Баянгол Шинэ-өргөө, ХЗСО, Хүүхдийн зуслан, Баянгол-цэцэрлэгт хүрээлэн, Баянгол сэлбэ), нийт 15 байгууллага нэгтгэгдсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2		8	
2	ОНӨААН		1	4	
	Дүн	2	1	12	0

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3 (дүүргийн ЗДТГ, ИТХ, Баянгол-Шинэ өргөө ОНӨААТҮГ) санал дүгнэлт өгсөн.

5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аудитаар нийт 291,560.3 мянган төгрөгийн 7 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

- Бараа материалын тодруулга тайланд орлогыг 189,535.4 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.(ИТХ)
- Данснаас хассан хөрөнгийн үлдэх өртгийг 401.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.(ИТХ)
- Тээвэр шатахууны зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр илүү, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 154.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.(ИТХ)
- Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 88.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. (ГБЕО)
- Эргэлтийн бус хөрөнгийг 90.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.(ДАА)
- Үндсэн хөрөнгийн үлдэх өртгийг 88,774.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн. (Хүүхдийн зуслан ОНӨААТҮГ)
- 6,515.9 мянган төгрөгийн авлагыг зардалд бүртгэсэн. (Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ)

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 3,166,984.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,094.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2,192,412.3 мянган төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 973,478.2 мянган төгрөгийн 19 зөвлөмж өгсөн.

5.1.1. Орон нутгийн байгууллага

Аудитаар нийт 3,076,786.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,192,412.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага (хариуцлага тооцуулах 1 албан шаардлага) хүргүүлж, 921,004.1 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 13 зөвлөмжийг шалгагдагч байгууллагад өгсөн.

Албан шаардлага

- Өмнөх оны аудитаар өгсөн 2 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдээгдэнэ” заалтыг зөрчиж байна. (ЗДТГ)

- Шүүхийн шийдвэрээр халагдсан 2 ажилтны ажилгүй байсан хугацааны 63,505.8 мянган төгрөгийн цалинг төсвөөс олгож, ажлаас чөлөөлсөн албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 *“Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2 “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, 103.3 “Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна” заалтыг зөрчиж байна. (ИТХ 48,610.2 мянга, ЗДТГ 14,895.6 мянга)*
- Оны шилдэг хэлтэс, ажилчдыг шагнахад 30,300.0 мянга, сургалтын арга хэмжээнд 3,565.0 мянган төгрөгийг нэр бүхий ажилтны хувийн данс руу шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалтыг зөрчиж байна. (ЗДТГ)*
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 33,884.6 мянган төгрөгийн ажил, гүйлгээ бүртгэсэн.(Төсвийн хэлэлцүүлгийн зардалд 12,054.6 мянга, удирдах ажилтны тайлангийн хуралд 16,830.0 мянга, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд сурталчлах зардал 5,000.0 мянга) нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.*“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7.“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчиж байна. (ЗДТГ)*

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Татварын бааз суурийг нэмэгдүүлж, татварын орлого төвлөрүүлэх зорилгоор 13 ажилтныг гэрээгээр ажиллуулж 129,249.3 мянган төгрөгөөр цалинжуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.3 “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” заалтыг хэрэгжүүлээгүй байна. (ЗДТГ)*

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, давхардуулсан цалин, урамшуулал төлөвлөхгүй байж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулж байх.

Илрүүлэлт 2:

Гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авч 17,334.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*” заалтуудыг тус тус зөрчсөн байна. (ЗДТГ)

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг аялал, хүлээн авалтын зардалд зарцуулахгүй байх, алдааг давтан гаргахгүй байх

Илрүүлэлт 3:

Төлөөлөгчдийн чадавхжуулах арга хэмжээний зардлын 24,000.0 мянган төгрөгийг Мөнх ундрах булаг ХХК руу шилжүүлснийг тус компанийн тусгай зөвшөөрөлтэй тулгахад сургалт явуулах эрх, үйл ажиллагааны чиглэлгүй байгаа нь төсвийг хяналтгүй зарцуулах үр дагаврыг бий болгож байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “*Хариуцлагатай байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”; 16 дугаар зүйлийн 16.5.5 “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” заалтуудыг зөрчсөн. (ИТХ)

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж, төсөв зарцуулж байх.

2. Хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Тайлант онд худалдан авсан 715,251.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжүүдийг ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгөөгүй, тэдгээрийг тооллогод хамруулж баталгаажуулаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “*Аж ахуйн нээж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*”, 5.1.3 “*жинхэнэ хэрэгжилтийн*”; 5.1.4 “*үнэн зөв байх*”; Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар 2 дугаар зүйлийн 2.1.4 “*Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх*” заалтыг хэрэгжүүлээгүй байна. (Дүүргийн хөрөнгө оруулалт)

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулж хэвших

Илрүүлэлт 2:

Дүүргийн төсвөөр санхүүжүүлсэн 35,169.8 мянган төгрөгийн зураг төсвийг тухайн төсөл арга хэмжээ хэрэгжихэд ашиглаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, 24 дүгээр зүйлийн 24.6 “*Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ*” заалтыг хэрэгжүүлээгүй байна. (Дүүргийн хөрөнгө оруулалт)

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулж байх

Илрүүлэлт 3:

Зураг төсөв бэлэн болоогүй байхад хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалт баталж, төсвийг тодотгосон, завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 24 дүгээр зүйлийн 24.6 “Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ” заалтыг хэрэгжүүлээгүй байна. (Дүүргийн хөрөнгө оруулалт)

Өгсөн зөвлөмж: Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгийн зардлыг төлөвлөхөд зураг төсвийг үндэслэн төлөвлөж байх

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт 1:

Үндсэн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдгийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, 12 дугаар зүйлийн 12.2 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72, 73 дугаар зүйлийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна. (Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв)

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэх, ашиглалт, хадгалалт хамгаалалт, бүртгэлд анхаарч ажиллах

5.1.2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд

Аудитаар нийт 90,197.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,094.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 36,629.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 52,474.1 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн.

Төлбөрийн акт

- Автомашины замын хөдөлгөөний торгууль 1,094.2 мянган төгрөгийг байгууллагаас төлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4. “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг зөрчсөн. (Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ)

Албан шаардлага

- Цалингийн нэмэгдлүүд нь нийтлэг мөрдөгдөх эрх зүйн актуудын шаардлага, шалгуурт бүрэн нийцэхгүй байна. Тухайлбал гадуур ажилласны нэмэгдэл, бүсийн ахлагчийн нэмэгдэл, давсны нэмэгдэл, гар утасны төлбөр зэрэг 36,629.5 мянган төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.4. “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн

- хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 “*утасны зардлаас бусад гар утасны зардал зарцуулахыг хориглоно*” заалттай нийцэхгүй байна. (Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ)
- НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлээгүй, тайлант хугацаанд нийт 2,466,315.4 мянган төгрөгийн орлогыг төлбөрийн цахим системд шивж бүртгээгүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14. “*“төлбөрийн баримт” гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг*”; 4.1.15. “*“дахин давтагдашгүй төлбөрийн дугаар” гэж худалдаа, үйлчилгээ эрхлэгч албан татвар суутган төлөгчийн татвар төлөгчийн дугаар, салбар, төлөөлөгчийн газартай бол салбарын дугаар, төлбөр тооцооны он, сар, өдөр, төлбөр тооцооны дэс дугаарыг дунд нь ямар нэг тэмдэгт хэрэглэлгүйгээр үргэлжлүүлэн тоон утгаар илэрхийлсэн дугаарыг*”, 5 дугаар зүйлийн 5.2. “*үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна.*”, 7 дугаар зүйлийн 7.1.1. “*Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ*”, 7.2.15 “*төрөөс олгож байгаа төсвийн санхүүжилт, татаас, урамшуулал*” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. (Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ)
 - Бараа материалын зарцуулалтыг тухай бүрд анхан шатны баримт хөтөлж, бүртгэлгүй нэг удаад бөөн дүнгээр зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.4. “*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*”, 13.7 “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. (Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ)

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт1:

Тайлант онд 5 харилцагчийн 30,784.1 мянган төгрөгийн авлага, 2 харилцагчийн 4,960.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 20.2.6. “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*,” заалттай нийцээгүй. (Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ)

Өгсөн зөвлөмж: Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай өглөг, авлагын тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт1:

2021 онд Баянгол ахмадын эмнэлэгт гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах зорилгоор нийт 420 ш 16,730.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэл шилжүүлэн ашиглуулж зарим бараа материалыг буцааж өгөөгүйд арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" заалттай нийцэхгүй байна.(Баянгол хүүхдийн зуслан ОНӨТҮГ)

Өгсөн зөвлөмж: Бодитоор байхгүй байгаа бараа материалыг шийдвэрлүүлж, зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
БГД.ИТХ	3	196,091.0			3	196,091.0	2	196,091.0				
БГД.ГБЕО	1	88.1			1	88.1	1	88.1				
БГД ДАА	1	90.5			1	90.5		90.5				
Орон нутгийн байгууллагын дүн	5	196,269.6			5	196,269.6	3	196,269.6				
БГД Баянгол Шинэ-өргөө	1	6,515.9			1	6,515.9	1	6,515.9				
БГД.Хүүхдийн зуслан	1	88,774.9			1	88,774.9	3	88,774.9				
ОНӨААНБ-ын дүн	2	95,290.8			2	95,290.8	4	95,290.8				
НИЙТ ДҮН	7	291,560.3			7	291,560.3	9	291,560.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
БГД.ИТХ	2	72,610.2			1	48,610.2	1	24,000.0				
БГД.ЗДТГазар	6	229,228.5			3	82,645.2	2	146,583.3	1			
БГД.ХО	3	750,420.8					3	750,420.8				
БГД.ЖДҮДэмжих төв	1	-					1	-				

Нийслэлийн Баянгол дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Орон нутгийн байгууллагын дүн	12	1,052,259.5	0	-	4	131,255.4	7	921,004.1	1		
БГД Баянгол Шинэ-өргөө	6	73,467.8	1	1,094.2	3	36,629.5	2	35,744.1			
БГД.Хүүхдийн зуслан	1	16,730.0					1	16,730.0			
ОНӨААНБ-ын дүн	7	90,197.8	1	1,094.2	3	36,629.5	2	52,474.1	-		
НИЙТ ДҮН	19	1,142,457.3	1	1,094.2	7	167,884.9	10	973,478.2	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
БГД. ГБЕО	1	61,340.0					1	61,340.0
БГД ЖДҮДТ	1	8,000.0					1	8,000.0
Орон нутгийн байгууллагын дүн	2	69,340.0					2	69,340.0
БГД Баянгол Шинэ-өргөө	1	-					1	-
ОНӨААНБ-ын дүн	1	0	0	0	0	0	1	0
Дүн	3	69,340.0	0	0	0	0	3	69,340.0
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
БГД. ЗДТГ	5	533,961.9	2	6,591.6			3	527,370.3
БГД.ИТХ	4	562,719.4			2	560,429.4	2	2,290.0
БГД.ДАА	1	10,836.8					1	10,836.8
БГД ХЗСО	1	-					1	-
Орон нутгийн байгууллагын дүн	11	1,107,518.1	2	6,591.6	2	560,429.4	7	540,497.1
НИЙТ ДҮН	14	1,176,858.0	2	6,591.6	2	560,429.4	10	609,837.0